



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/501

Булган сум

┌ Сурын харвааны цол олгох тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234, Их Монгол Улс байгуулагдсаны 819, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104, Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн их баяр наадмын Үндэсний сурын харваанд түрүүлсэн Булган аймгийн Гурванбулаг сумын уугуул, “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”-ны харваач Аймгийн гарамгай харваач, спортын мастер Дамдинжамцын Мөнхжаргал, Булган аймгийн Бүрэгхангай сумын уугуул “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”-ны харваач Аймгийн гарамгай харваач, спортын мастер Галбадрахын Намуунд “Аймгийн мэргэн” цол, хоёрдугаар байр эзэлсэн Булган аймгийн Булган сумын харьяат “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”-ны харваач спортын дэд мастер Балжиннямын Батбаяр, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул Булган аймгийн Баян-Агт сумын харьяат “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”, “Хөвсгөл Их тайга” ХХК-ийн харваач Аймгийн гоц харваач, спортын мастер Дэмбэрэлийн Отгонбаярт “Аймгийн гарамгай харваач” цол, гуравдугаар байр эзэлсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын харьяат “Хангарьд спорт клуб”-ийн харваач Отгонбаяр овогтой Тээсүүд “Аймгийн гоц харваач” цол, дөрөвдүгээр байр эзэлсэн Булган аймгийн Баян-Агт сумын харьяат “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”-ны харваач Сумын мэргэн Батбаярын Мягмарбат, Булган аймгийн Бугат сумын уугуул “Дайчин вангийн мэргэд сурын холбоо”-ны харваач Сумын мэргэн Энхсайханы Энхцэцэгт “Аймгийн онч харваач” цолыг тус тус олгосугай.

2.Шинээр цол авсан харваачдад цолны үнэмлэх олгохыг баяр наадмын Үндэсний сурын харвааны салбар хороо (Д.Төгсбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010694